



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ  
ИНСТИТУТИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/27/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Н.Баттөгөлдөр  
Утас: 261628 Цахим хаяг: [battuguldum@audit.gov.mn](mailto:battuguldum@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Энич аудит" ХХК  
Захирал: Г.Чинтуяа  
Утас: 70002115 Цахим хаяг: [enichaudit@gmail.com](mailto:enichaudit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
<b>3.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>14</b>
<b>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....</b>	<b>14</b>
<b>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....</b>	<b>15</b>
<b>3.4 Материаллаг байдал .....</b>	<b>15</b>
<b>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....</b>	<b>15</b>
<b>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....</b>	<b>15</b>
<b>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....</b>	<b>17</b>
<b>3.8 Аудитын гол асуудал .....</b>	<b>17</b>
<b>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....</b>	<b>17</b>
<b>3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>17</b>
<b>3.10 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>18</b>
<b>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....</b>	<b>18</b>
4. Аудитын илрүүлэлт .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.БАТБААТАР ТАНАА

2022.02.24 № 07/289  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.20\Bichig\_Khercgl\Yawsan\_Bichig\2022\0224 Auditin 2 Gazar-4.Docx

001050168

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>36,508,345.00</b>	<b>49,897,979.00</b>
	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,508,345.00</b>	<b>49,897,979.00</b>
100	Хангамжийн материал	36,508,345.00	49,897,979.00
110	Бичиг хэргийн материал	10,931,842.00	8,292,257.00
120	Аж ахуйн материал	6,539,875.00	12,293,451.00
130	Сэлбэг хэрэгсэл	5,343,200.00	2,075,000.00
140	Түлш, шатах тослох материал	2,056,000.00	4,216,000.00
190	Бусад хангамжийн материал	11,637,428.00	23,021,271.00
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>116,375,926.11</b>	<b>81,940,508.96</b>
	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>116,375,926.11</b>	<b>81,940,508.96</b>
200	Биет хөрөнгө	91,317,777.21	76,960,962.58
203	Авто-тээврийн хэрэгсэл	163,377,700.00	163,377,700.00
204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(163,377,700.00)	(163,377,700.00)
205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	267,266,299.27	231,048,239.10
206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(224,817,752.27)	(192,611,234.64)
207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,625,989.89	164,305,889.89
208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(119,307,759.68)	(131,332,931.77)
217	Номын фонд	5,551,000.00	5,551,000.00
300	Биет бус хөрөнгө	25,058,148.90	4,979,546.38
301	Програм хангамж	84,882,930.00	84,882,930.00
302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(59,824,781.10)	(79,903,383.62)
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>152,884,271.11</b>	<b>131,838,487.96</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	-
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
300	Өглөг	-	-
	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>152,884,271.11</b>	<b>131,838,487.96</b>
	Засгийн газрын хувь оролцоо	152,884,271.11	131,838,487.96
200	Хуримтлагдсан үр дүн	152,884,271.11	131,838,487.96
210	Өмнөх үеийн үр дүн	166,536,467.34	152,884,271.11
220	Тайлант үеийн үр дүн	(13,652,196.23)	(21,045,783.15)
	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>152,884,271.11</b>	<b>131,838,487.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>775,673,656.00</b>	<b>831,817,693.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>30,367,620.00</b>	<b>-</b>
1200	Өмчийн орлого	30,367,620.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	30,367,620.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>745,306,036.00</b>	<b>831,817,693.80</b>
1310	Улсын төсвөөс	722,003,300.00	726,508,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	722,003,300.00	726,508,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,302,736.00	105,309,293.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	83,889,166.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,302,736.00	21,420,127.80
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>789,325,852.23</b>	<b>852,863,476.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>789,325,852.23</b>	<b>852,863,476.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>714,140,748.14</b>	<b>830,226,674.99</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	525,281,401.01	592,917,978.27
210101	Үндсэн цалин	508,866,712.01	550,830,417.17
210102	Нэмэгдэл	-	112,802.00
210105	Гэрээт ажлын цалин	16,414,689.00	41,974,759.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,176,314.88	82,376,795.63
210201	Тэтгэвэрийн даатгал	46,440,699.65	60,149,897.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,410,285.99	5,854,596.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,102,629.74	4,440,774.55
210204	Ажилгүйдлийн даатгал	995,752.86	1,084,684.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,226,946.64	10,846,842.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,080,000.00	-
210304	Байрны түрээс	1,080,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	56,775,916.02	74,998,297.94
210401	Бичиг хэрэг	15,164,449.00	10,715,585.00
210402	Тээвэр, шатахуун	6,924,970.00	4,440,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,370,784.02	31,468,134.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	762,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,577,691.00	27,611,778.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,338,022.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,464,700.00	5,594,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,084,700.00	5,594,900.00
210604	Урсгал засвар	1,380,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,372,500.00	-
210702	Дотоод албан томилолт	3,372,500.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,080,765.00	5,498,522.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	547,000.00	982,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	266,765.00	325,922.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	190,000.00	190,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,909,151.23	68,840,181.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	575,153.00	579,234.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	135,000.00	13,262,000.00
210914	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,198,998.23	54,998,947.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,185,104.09</b>	<b>22,636,801.96</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,185,104.09	22,636,801.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,185,104.09	10,219,001.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,417,800.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,417,800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(13,652,196.23)</b>	<b>(21,045,783.15)</b>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>(13,652,196.23)</b>	<b>(21,045,783.15)</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	<b>166,536,467.34</b>	<b>166,536,467.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(13,652,196.23)	(13,652,196.23)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	<b>152,884,271.11</b>	<b>152,884,271.11</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(21,045,783.15)	(21,045,783.15)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	<b>131,838,487.96</b>	<b>131,838,487.96</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>745,306,036.00</b>	<b>831,817,693.80</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>745,306,036.00</b>	<b>831,817,693.80</b>
1310	Улсын төсвөөс	722,003,300.00	726,508,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	722,003,300.00	726,508,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,302,736.00	105,309,293.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	-	83,889,166.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,302,736.00	21,420,127.80
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>745,306,036.00</b>	<b>831,817,693.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>745,306,036.00</b>	<b>831,817,693.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>669,300,931.91</b>	<b>808,524,891.84</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	525,281,401.01	592,917,978.27
210101	Үндсэн цалин	381,810,237.64	387,213,195.13
210102	Нэмэгдэл	92,681,313.32	112,436,073.31
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	34,375,161.05	51,293,950.73
210105	Гэрээт ажлын цалин	16,414,689.00	41,974,759.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,176,314.88	82,376,795.63
210201	Тэтгэвэрийн даатгал	46,462,591.90	60,149,897.90
210202	Тэтгэмжийн даатгал	5,359,899.61	5,854,596.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,095,840.62	4,440,774.55
210204	Ажилгүйдлийн даатгал	999,034.78	1,084,684.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,258,947.97	10,846,842.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,080,000.00	-
210304	Байрны түрээс	1,080,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	58,219,528.02	90,066,631.94
210401	Бичиг хэрэг	14,344,199.00	4,753,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,758,000.00	6,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,370,784.02	31,468,134.94
210404	Ном, хэвлэл	-	18,680,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,525,000.00	2,085,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,221,545.00	26,479,697.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,329,500.00	22,449,130.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,067,800.00	22,449,130.00
210604	Урсгал засвар	2,261,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,727,470.00	-
210702	Дотоод албан томилолт	3,727,470.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,080,765.00	5,498,522.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	547,000.00	982,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	266,765.00	325,922.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	190,000.00	190,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,405,953.00	15,215,834.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,502,953.00	579,234.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	903,000.00	14,636,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,005,104.09</b>	<b>23,292,801.96</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,185,104.09	10,219,001.96
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,185,104.09	10,219,001.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	820,000.00	13,073,800.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	12,417,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	656,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	-	-
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>713,434,600.00</b>	<b>703,215,598.80</b>	<b>10,219,001.20</b>
<b>12</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>713,434,600.00</b>	<b>703,215,598.80</b>	<b>10,219,001.20</b>
122005	Улсын төсвөөс санхүүжих	713,434,600.00	703,215,598.80	10,219,001.20
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>713,434,600.00</b>	<b>703,215,598.80</b>	<b>10,219,001.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>713,434,600.00</b>	<b>703,215,598.80</b>	<b>10,219,001.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>713,434,600.00</b>	<b>703,215,598.80</b>	<b>10,219,001.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>551,046,300.00</b>	<b>550,943,219.17</b>	<b>103,080.83</b>
210101	Үндсэн цалин	365,238,900.00	387,213,195.13	(21,974,295.13)
210102	Нэмэгдэл	133,007,400.00	112,436,073.31	20,571,326.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,800,000.00	51,293,950.73	1,506,049.27
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>79,071,900.00</b>	<b>78,289,576.63</b>	<b>782,323.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	56,180,600.00	56,062,678.90	117,921.10
210202	Тэтгэмжийн даатгал	5,722,800.00	5,854,596.96	(131,796.96)
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,578,300.00	4,440,774.55	137,525.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,144,600.00	1,084,684.21	59,915.79
210205	Эрүүл мэндийн даатгал	11,445,600.00	10,846,842.01	598,757.99
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>58,700,700.00</b>	<b>50,943,947.00</b>	<b>7,756,753.00</b>
210401	Бичиг хэрэг	11,296,000.00	4,276,800.00	7,019,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,624,900.00	6,600,000.00	24,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,396,900.00	11,737,450.00	(340,550.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,115,000.00	2,085,000.00	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,267,900.00	26,244,697.00	1,023,203.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,854,200.00</b>	<b>7,225,100.00</b>	<b>629,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,854,200.00	7,225,100.00	629,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,062,900.00</b>	<b>5,498,522.00</b>	<b>564,378.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	982,600.00	982,600.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	325,922.00	70,078.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	103,200.00		103,200.00
210807	Газрын төлбөр	581,100.00	190,000.00	391,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,698,600.00</b>	<b>10,315,234.00</b>	<b>383,366.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	698,600.00	579,234.00	119,366.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	9,736,000.00	264,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,417,800.00	12,417,800.00	

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	656,000.00	656,000.00	
<b>26</b>	<b>ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг			
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	
<b>6 - ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
610001	Төсвийн байгууллага	1	1	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40	40	
620001	Удирдах ажилтан	7	7	
620002	Гүйцэтгэх ажилтан	30	30	
620003	Үйлчлэх ажилтан	3	3	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>105,309,293.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>105,309,293.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>105,309,293.04</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		41,974,759.10
210105	Гэрээт ажлын хөлс		41,974,759.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,087,219.00
210201	Тэтгэврийн даатгал		4,087,219.00
2104	Хангамж, бараа материалын зардал		39,122,684.94
210401	Бичиг хэрэг		477,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		19,730,684.94
210404	Ном, хэвлэл		18,680,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		235,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,224,030.00
210601	Багаж, техник хэрэгсэл		15,224,030.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал		4,900,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,900,600.00
<b>26</b>	<b>ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>0.76</b>
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		0.76
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>105,309,293.80</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		105,309,293.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		83,889,166.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		21,420,127.80
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад худалдан авалтын ажил гүйлгээг заавар журмын дагуу бүртгэх, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 04-нөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Энич аудит ХХК-ийн ахлах аудитор С.Наранцэцэг, аудитор Д.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Чинтуяа хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25- ны өдрийн 1/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын зорилго нь төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн суурь судалгаа шинжилгээ хийж, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулахад оршино.

Дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар судалгаа, шинжилгээ хийх, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах
- Нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар судалгаа, шинжилгээ хийх, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах, хяналт үнэлгээ хийх
- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Мөн тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод хяналт нь ХНХСИ-ийн ХШҮДА-ын 2021 оны байгууллагын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний дагуу нийт 33 ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсөвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 852,863.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,528.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувь буюу 6,396.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,045.8 мянган төгрөгөөр буюу 13.7 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Бараа материал	36,508.3	49,897.9	13,389.6
Үндсэн хөрөнгө	116,375.9	81,940.5	(34,435.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>152,884.3</b>	<b>131,838.5</b>	<b>(21,045.8)</b>
Хуримтлагдсан үр дүн	152,884.3	131,838.5	(21,045.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>152,884.3</b>	<b>131,838.5</b>	<b>(21,045.8)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материалаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 49,898.0 мянган төгрөг болж, 13,389.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 62,686.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 49,297.1 мянган төгрөгийг зарцуулсан ;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 81,940.5 мянган төгрөг болж, 34,435.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 20,563.5 мянган төгрөгөөр худалдан авалт хийж, 55,101.7 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А-1/1966 тоот тогтоолын дагуу акталж, 54,998.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн.



### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 772,804.2 мянган төгрөг, үүнээс нийт зардалд 772,804.2 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 46,295.8 мянган төгрөгийг бууруулан 726,508.4 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотгол хийгдээгүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 726,508.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 726,508.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 716,289.4 мянган төгрөгийг зарцуулж, 10,219.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 716,289.4 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 885.4 мянга, хангамж, бараа материалын зарлыг 7,756.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 629.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 564,4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 383.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

Д/Д	Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	726,508.4	716,289.4	10,219.0	98.6%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	713,434.6	703,215.5	10,219.0	98.6%
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	13,073.8	13,073.8	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа”-ны ажил болон Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд гэрээт ажил хэрэгжүүлэхэд 105,309.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 46,062.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 39,122.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 15,224.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 4,900.6 мянган төгрөг нийт 105,309.3 мянган төгрөгийг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувьтай байна. Тус хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон нийт зардалд 726,508.4 мянган төгрөгийг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр нийт 716,289.4 мянган төгрөгийг зарцуулж 98.6 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 1,4 хувийн зөрүүтэй ажилласан нь төсвийг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас бусад үйл ажиллагааны зардлын 9.7 хувь буюу 9,333.6 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт нь нийт 2,739,555.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 180,191.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх.", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хоцроож, 5,656.0 мянган төгрөгийн орлогын 1 мэдээллийг байршуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилт 98.2 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Жилийн эцсийн үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг тоолсон Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны 12 сарын 06 ны өдрийн А/15 тоот тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Land rover Defender болон Хьюндэй Соната-7 маркийн автомашиныг актлах санал гаргасан байна. Авто тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэгээр оруулж зохих засвар үйлчилгээг хийж үйл ажиллагаандаа хөрөнгийг дахин ашиглах боломжийг судлахад анхаарах хэрэгтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,990.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,650.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,339.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 5,990.0 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 8,528.6 мянган төгрөгөөс 2,538.6 мянган төгрөг хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн.

##### 4.1 Төлбөрийн акт

Захиргааны нэр бүхий 4 ажилтны жилийн хугацаанд ажилласан илүү цагийг нэгтгэн тооцож, 3,650.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг жилийн эцэст олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т "Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 -т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам-ын 3.2. "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журамд зааснаас бусад тохиолдолд захирааны ажилтанд илүү цагийн хөлсийг тооцож олгохгүй байх. Төлбөрийн акт тогтоох.

##### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Хөрөнгийн гүйлгээтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 2,339.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа эд хогшил, урсгал зардлын дансаар шууд дамжуулан бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэн зөв байх" зарчим, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1 хавсралт 4.33 (а) "Төсвийн санхүүжилтээр үндсэн хөрөнгө худалдан авахад..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, ангилал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлүүдийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа тооцооны дансаар дамжуулан бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

Д/д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа зөрчлийн		Үүнээс									
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	АХГ-2022/27/Н А-СТА-ТШЗ	Нэр бүхий 4 захиргааны ажилтанд жилийн хугацаанд ажилласан илүү цагийг нэгтгэн тооцож 12 дугаар сард илүү цагийн хөлс олгосон.	Хууль, журамд зааснаас бусад тохиолдолд захирааны ажилтанд илүү цагийн хөлсийг тооцож олгохгүй байх.	1	3,650.5					1	3,650.5				
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	АХГ-2022/27/Н А-СТА-ТШЗ	2021 оны сүүлийн хагас жилд үндсэн хөрөнгийг орлогод авахдаа зардлын дансаар дамжуулан бүртгэсэн.	Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа тооцооны дансаар дамжуулан бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	2,339.5									1	2,339.5
	Дүн				2	5,990.0					1	3,650.5			1	2,339.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт	АХГ-2022/27/Н А-СТА-ТШЗ	2021 онд 110 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах	1						1			1		
	Дүн				1						1			1		
	Нийт дүн				3	5,990.0					2	3,650.5		1	1	2,339.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 06/A0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/27/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захиргааны нэр бүхий 4 ажилтны жилийн хугацаанд ажилласан илүү цагийг нэгтгэн тооцож, 3,650,500 төгрөгийн илүү цагийн хөлсийг жилийн эцэст олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2 "Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.2 "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно." гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, төлбөрийн гүйлгээний утга: Нэр бүхий 4 ажилтны илүү цагийн хөлс, 3,650,500 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкны Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбаатар, ахлах нягтлан бодогч Б.Пүрэвцэцэг нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭНИЧ-АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Д.УРТНАСАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264200

9019120396

\\FD-10.10.20\Bchul\_Kherreg\Akt\2022\0225 Auditin 2 Газар-13.Docx

0010S0052



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 25 № 31/А0150058  
АХГ-2020/27/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 2,739,555,600 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулахаас 180,191,040 төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх.", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын ахлах нягтлан бодогч Б.Пүрэвцэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбаатарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Д.УРТНАСАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264238

\\10.10.10.20\Bichig\_Kherel\Alban Shaardlaga\2022\0725\_Auditin 2 Gaar-57.Docx

001080166





## ТЭМДЭГЛЭЛ

A series of 20 horizontal dotted lines for writing the conclusion.